



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/18

Мандалговь

Газар усны нэр тодруулах ажил /Гурвансайхан,
Говь-Угтаал, Сайнцагаан, Өндөршил, Луус, Дэрэн
зөвлөхийн үйлчилгээний үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Газар усны нэр тодруулах ажил (Гурвансайхан, Говь-Угтаал, Сайнцагаан, Өндөршил, Луус, Дэрэн) зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Түвшинбаяр (Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Ё.Дашням (Иргэний төлөөлөл)

Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн)

Э.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060059